

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮН

2018.03.12

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2 дахь заалтын дагуу төсвийн шууд захирагч нарын 2017 оны санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 173 төсвийн байгууллага хамрагдахаас Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан журмын дагуу шалгуур хангасан 13 байгууллагад итгэл үзүүлж, аудит хийлгүй өнжөөсөн. Үлдсэн 160 байгууллагаас түүвэрт хамруулан шалгасан 98, бие даасан дүгнэлт гаргасан 62 байгууллага байгаагаас 57 байгууллагад “Зөрчилгүй”, 5 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргажээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй”, “Хязгаарлалттай”, “Сөрөг”, “Дүгнэлт өгөхөөс татгалзах” гэсэн 4 төрлийн дүгнэлт өгдөг. “Хязгаарлалттай” болон “Сөрөг” санал дүгнэлт авсан байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцох албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлдэг.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **11,782.1** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад залруулж болох **9,115.6** сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Аудитын явцад илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгахын тулд дөрвөн төрлийн арга хэмжээ авдаг. Орлого дутуу төвлөрүүлсэн, мөнгөн хөрөнгө дутсан мөн улсад болон байгууллагад хохирол учруулсан тохиолдолд акт тавьдаг. Тиймээс төсөвт буцааж төвлөрүүлэх шаардлагатай гэсэн үг. Харин шалгагдагч байгууллагын удирдлагаас богино хэмжээнд авч хэрэгжүүлэх нь тухайн алдаа дутагдлыг таслан зогсоох дахин давтахгүй байхад чухал нөлөөтэй гэж үзвэл албан шаардлага хүргүүлдэг. Акт, албан шаардлага бол зайлшгүй биелэгдэх шинж чанартай. Харин тухайн үйл ажиллагаа болон тайлагналыг сайжруулахын тухайд зөвлөмж өгдөг. Мөн хууль тогтоомж зөрчсөнөөс гадна гэмт хэргийн шинжтэй байх магадлалтай зөрчлийг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулдаг. Тэгэхээр **2,666.5** сая төгрөгийн алдаа зөрчлүүдэд дээрх арга хэмжээг авсан.

1,647.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр **495.3** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахаар 25 заалт бүхий **73.5** сая төгрөгийн зөвлөмжийг тус тус өглөө.

Хулд сумын Тусгай зориулалтын сан, Өлзийт сумын Цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомж зөрчсөнөөс гадна гэмт хэргийн шинжтэй байх магадлалтай **6.8** сая төгрөгийн зөрчлийг Төрийн аудитын тухай хуулийн 15.3-т зааснаар Цагдаагийн газарт шалгуулахаар хүргүүлсэн байгаа.

Сум хөгжүүлэх сан

Сум хөгжүүлэх сан нь 2017 оны жилийн эцсийн байдлаар 707 иргэнд 2,956.6 сая төгрөгийн зээл, 211.5 сая төгрөгийн зээлийн хүү, алдангийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс 326 иргэн 927.8 сая төгрөгийн хугацаа хэтрэлттэй зээлийн үлдэгдэлтэй байна.

Аудитаар нийт 509.2 сая төгрөгийн зөрчил илэрч, 7.7 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 28.6 сая төгрөгийн зөрчлийг арилган таслан зогсоохоор албан

шаардлага, 472.9 сая төгрөгийн төлбөрийг барагдуулахаар хугацаатай төлбөрийн акт тогтоолоо.

Өмнөх аудитаар хугацаа хэтрэлттэй зээлийн үлдэгдлийг барагдуулахаар өгсөн 442.5 сая төгрөгийн төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй Адаацаг, Гурвансайхан, Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өлзийт сумдад Төрийн аудитын тухай хуулийн 28.2-т заасны дагуу хариуцлага тооцох саналыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Сайнцагаан сум нь өмнөх аудитаар өгөгдсөн төлбөрийн актыг барагдуулахаар бүх хугацаа хэтрэлттэй зээлдэгч нарыг шүүхэд нэхэмэжлэн, хугацаатай эвлэрлийн гэрээ байгуулж, Шийдвэр гүйцэтгэх албанд өгч ажилласан тул актыг хэрэгжүүлэх шатанд байгаа гэж үзлээ.

Гурвансайхан сум нь хугацаа хэтрэлттэй зээлдэгчид давуу байдал олгон, Сум хөгжүүлэх сангийн журмыг зөрчиж, 33.0 сая төгрөгийн зээл олгосон тул ашиг сонирхол үүссэн байж болзошгүй гэж үзэн, шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 404.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, залруулах боломжтой 62.1 сая төгрөгийн алдааг залруулж, 342.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Илэрсэн зөрчлийн агуулгыг харахад өмнөх оны аудитаар илэрсэн зөрчил давтан гарч байгаа нь ажил хариуцсан албан хаагч нарын хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

Жич: Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитын дүн дээр дурдсан 11,782.1 төгрөгийн нийт зөрчлийн дүнд орсон болно.

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР